

**«БНМАУ, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСАГ БА СОЁЛЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР» БА МОНГОЛ-ХЯТАДЫН СОЁЛЫН  
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА: 1950-ИАД ОН**

*Хэрээд Жамсрангийн Урангуа  
МУИС-ийн Түүхийн тэнхим, доктор Sc.D, профессор  
Email: uranguakhereid@gmail.com*

*Бөхөө  
Шанхайн Хуадун багшийн их сургууль, доктор Ph.D  
Email: bukh0204@163.com*

Соёлын харилцааны асуудал бол орчин үеийн улс хоорондын харилцааны чухал хэсэг боловч судлагдахуун болохынхоо хувьд улс хоорондын харилцааг судлах улс төр, эдийн засгийн судалгааны хавсарга болж, ихэнхдээ дутуу судлагддаг эсхүл орхигддог онцлогтой байсаар иржээ. Гэтэл үнэндээ улс хоорондын соёлын харилцаа нь өргөн хүрээг хамарсан, нарийн төвөгтэй, олон салбарыг уялдуулсан цогц судлагдахуун гэдгийг сүүлийн үеийн судалгааны хандлага харуулах болсон бөгөөд Хүйтэн дайны үеийн Монгол, Хятадын соёлын харилцааг энэхүү шинэ хандлагаар тусгайлан авч үзэх шаардлага байгаа юм. Өнөөг хүрэхэд Хүйтэн дайны үеийн Монгол, Хятадын харилцаан дахь соёлын асуудал нь тодорхой салбарын судалгааны хэмжээнд саланги тусдаа алаг цоог хийгдэж, дэлхийн түвшний судалгааны шинэ хандлагад нийцэх түвшинд хүрч судлагдаж чадалгүй орхигдсон хэвээр байна.

Хэдийгээр Монгол, Хятад хоёр талын соёлын харилцаа мянганаар тоологдох жилийн урт удаан хугацааны түүх уламжлалтай ч албан ёсны соёлын харилцааг дөнгөж XX зууны хоёрдугаар хагасаас л эхлүүлсэн байдаг. Чухамдаа XX зууны эхнээс л харилцан сөргөлдсөн байдалд өрнөсөн Монгол, Хятадын харилцаанд шинэ эргэлтийн цэг авч ирсэн түүхэн үйл явдал бол 1949 онд социалист шинэ Хятад улс буюу БНХАУ байгуулагдсан явдал ба БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтсон явдал юм. Дэлхий даяар Хүйтэн дайн өрнөж байсан тэр үед БНМАУ ба БНХАУ нь хоёул социалист лагерь хэмээх эвсэлд харьяалагдсан тул тэрхүү эвслийн бүтэц нь хоёр орны цаашдын харилцааны хэм хэмжээг тодорхойлж өгсөн юм. Тиймийн учир хоёр улс соёлын харилцааг хөгжүүлэхдээ нэг талаар түүхэн сөрөг хүчин зүйлийн нөлөөг аль болох бага түвшинд байлгах, нөгөө талаар тухайн цагийнхаа хөгжлийн замналын үзэл санаа, үнэт зүйлийг удирдлага болгон “Пролетарийн интернационализм”-ыг баримтлахыг чухалчлах болж, үр дүнд нь соёлын харилцааг цоо шинээр өргөн хүрээнд богино хугацаанд амжилттай хөгжүүлж чадсан билээ.

Хоёр талын байгуулсан анхны соёлын харилцааны тухай хэлэлцээр бол өнөөдөр бид ойг нь тэмдэглэж буй 1952 онд байгуулагдсан «БНМАУ, БНХАУ-

ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай» хэлэлцээр билээ.

Ингээд энэхүү илтгэлд тус хэлэлцээрийн хүрээнд XX зууны 50-60-аад онд өрнөсөн соёлын харилцааны мөн чанар, тус хоёр орны харилцааг нягтруулан хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг зэргийг түүхэн хөгжилд нь үечлэн авч үзсэн болно. Илтгэлийн дүгнэлтийн хэсэгт нам хоорондын харилцаа дээр суурилсан соёлын харилцаа ямар төгсгөлд хүргэдгийг харуулсан амуй.

### **БНМАУ, БНХАУ-ын хооронд тогтсон соёлын харилцааны эхний үе шат (1949-1953 он)**

1950-иад оны эхэн үеийн Монгол, Хятадын соёлын харилцааны гол зорилго нь соёлын идэвхтэй солилцоо, хамтын ажиллагаагаар дамжуулан албажаад удаагүй хоёр орны харилцааг эрчимжүүлэх гол чиглэл болгохын зэрэгцээ нөгөө талаар түүхэн хүчин зүйлээс үүдэлтэй хоёр ард түмний харилцан бие биеийнхээ талаарх сөрөг үзэл хандлагыг өөрчлөх явдал байв. Энэ асуудалтай тулгарсан тус хоёр улс хоёул социалист улс байсны хувьд пролетарийн интернационализмыг шинэ харилцаа буй болгох нийтлэг үндэслэл болгон ашиглаж эхлэв. Чингэхдээ пролетарийн интернационализмын онолыг хоёр утгаар онцлон хэрэглэх болов. Нэгдүгээрт: Монгол, Хятадын түүхэн сөрөг харилцааны үндэс нь үндэстний сөргөлдөөнт асуудал гэдгийг үгүйсгэж, бүх бурууг ноёлогч ангид тохож, хоёр орны ард түмэн ангийн нийтлэг эрх ашгийн үүднээс найрсаг харилцааг үргэлж хүсдэг хэмээн тайлбарлах болов. Энэ логикийн дагуу социалист “Шинэ Хятад” нь Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэсээр ирсэн “Хуучин Хятад”-аас бүрэн ялгагдан ХКН нь Монголын ард түмний сонголтыг үргэлж хүндэтгэдэг холбоотон нам хэмээн сурталчилж байв. Ингээд БНМАУ ба БНХАУ-ын харилцаа эрх тэгш, найрсаг, харилцан туслалцах зарчмын үндсэн дээр “Ах дүүгийн харилцаа” хэмээн тодорхойлогдох болжээ. Хоёрдугаарт: пролетарийн интернационализмын дагуу БНМАУ, БНХАУ нь ижил түүхэн эх сурвалжийг эзэмшсэн нь капиталист дарлалаас чөлөөлсөн Октябрийн хувьсгалын үзэл санаа, эрх баригч намууд нь Марксизм-ленинизмын сургаалыг удирдлага болгосон, социализм хэмээх нэг лагерьд харьяалагдсан, социалист байгуулалтын ижил загварыг дуурайсан нь Зөвлөлтийн загвар, мөн ижил дайсантай тэмцсэн нь империализм байв. Эдгээр утга нь хоёр улсын ижил төстэй байдлыг тодотгож байв.

Өмнө дурдсанчлан, энэ үеийн соёлын солилцооны нэг гол зорилго нь түүхэн сөрөг хүчин зүйлийг арилгах, Монгол, Хятадын хооронд шинэ харилцаа тогтооход тус дөхөм үзүүлэх явдал байв. Үүний тулд хоёр улсын Засгийн газар, нэгдүгээрт: пролетарийн интернационализмын онолын

дагуу сонин, радио, товхимол зэрэг мэдээллийн хэрэгслийг ашиглан бие биеийнхээ хувьсгалт түүх, социалист бүтээн байгуулалтыг сурталчилж байв. Хоёрдугаарт: кино үзүүлэх, гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах, уран зохиолын бүтээл орчуулах замаар Монгол, Хятадын хамгийн сүүлийн үеийн социалист шинж чанартай соёл, урлагийн бүтээлийг хоёр орны ард түмэнд харилцан танилцуулав. Гуравдугаарт: оюутан сурагч болон соёлын төлөөлөгчдийн солилцоогоор дамжуулан хил дамнасан хүн хоорондын солилцоог өрнүүлэв.

Одоо тухайн үеийн нэг тодорхой жишээг авч үзье. 1952 онд болсон «Монгол, Хятадын найрамдлын арав хоног» соёлын арга хэмжээг явуулсан нь хоёр улсын хоорондын анхны том соёлын солилцооны үйл явдал байлаа. Шинэ Хятад улсын шинэ дүр төрхийг бүрдүүлэх зорилгоор Монголын тал Хятадын социалист бүтээн байгуулалтын ололт амжилтыг улс орон даяар сурталчлах арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулав. Энэхүү Хятадын шинэ дүр төрх нь түүхэн шалтгааны улмаас Монголын нийгэмд гүн бат оршсоор байсан Хятадын талаарх сөрөг сэтгэгдлийг сааруулж, эерэг сэтгэгдлийг буй болгоход чиглэгджээ. Соёлын солилцооны ийм бодлогын хүрээнд талууд хоёр орны харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх нийтлэг үндэслэлийг олж авсан байна. Үнэндээ энэхүү арга хэмжээг явуулах үед хоёр улсын хоорондын анхны чухал хэлэлцээрийг зохион байгуулах ажил мөн сүүлийн шатанд хүрээд байв.

### **«БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулагдсан нь**

Хэдийгээр хоёр тал дипломат байгууллагуудаараа дамжуулан соёлын харилцааг хөгжүүлж эхэлсэн боловч анхандаа хоёр орны соёлын байгууллагууд хоорондоо шууд харилцаж байсангүй. Мөн соёлын солилцооны талаарх тодорхой эрх зүйн зохицуулалт байгаагүй тул хоёр орны соёлын харилцаа урсгал шинжтэй туйлын хязгаарлагдмал түвшинд хэвээр байжээ. Гэвч хоёр улсын удирдагчдын шууд оролцоо энэхүү нөхцөл байдлыг өөрчилсөн байна. 1950 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Хятадын дэд ерөнхийлөгч Лю Шаоци Монголын элчин сайд Б.Жаргалсайханыг хүлээн авч уулзахдаа БНХАУ нь БНМАУ-тай соёлын харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм<sup>1</sup>. Эл хоёр эрхмийн 3 хоногийн дараах бас нэгэн уулзалтаар Лю Шаоци соёлын талаарх асуудлыг дахин дурдав. Тэрбээр одоогийн байдлаар хоёр орны эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд бэрхшээлтэй ... (учраас) юуны өмнө бид соёлын талаар харилцах нь чухал хэмээн онцлоод үүнээс гадна БНМАУ-д кирилл монгол үсэг ба мал эмнэлгийн

<sup>1</sup> 沈志华编, 俄罗斯解密档案选编: 中苏关系 (kindle版5号字体), 上海, 东方出版中心, 2015年, 第20629-20676页.

чиглэлээр хүн суралцуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.<sup>2</sup> Улмаар 8 дугаар сард Хятадын ерөнхий сайд Жоу Энълай бас хоёр орны соёлын харилцааг өргөжүүлэх саналаа илэрхийлж байв. Тэрбээр БНМАУ-д сурагч явуулах, ном хэвлэл, кино зураг, урлагийн бригад солилцох зэрэг асуудлыг Монголын талд дурджээ.<sup>3</sup> Ийнхүү соёлын талаар харилцах асуудлыг Хятадын тал анхлан санаачлан, тодорхой саналуудыг дэвшүүлсэн байдаг ажээ.

Монголын тал Хятадын удирдагчдын хүсэлтийг дуртайяа хүлээн авсан ба тийнхүү талархан хүлээн авахад хүргэсэн нэг хүчин зүйл нь Монголын удирдагч Х.Чойбалсан Өвөр Монголтой соёлын харилцааг хөгжүүлэхийг ихэд эрмэлзэж байсан явдал амуй. Үүгээр ч зогсохгүй Монголын тал эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийг тус тус байгуулах санал тавьсан юм. Эдгээр хэлэлцээрүүдийн яриа хэлэлцээний явцыг хоёр үе шатанд хувааж болно. Үүнд:

-Анхны үе шатанд Монголын Элчин сайдын яам Хятадын Соёлын яам ба Худалдааны яамтай тус тус хэлэлцээ хийсэн нь доорх мэт.

1951 оны 10 дугаар сарын 6-ны өдөр БНМАУ-ын элчин сайд Б.Жаргалсайхан БНХАУ-ын Соёлын Яамны сайд Шэн Янбин-д Монголын талын боловсруулсан соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн төлөвлөгөөг танилцуулсан байна. ЗХУ-тай байгуулсан Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн туршлагад үндэслэн Монголын тал 1-д, хоёр орны оюутан сурагчдыг харилцан суралцуулах ба тэдгээрийг сургах журмыг тогтоох, 2-т, хоёр орны жүжигчдийн бригад болон биеийн тамирын командуудыг харилцан солилцож тоглуулах, 3-т, хоёр орны урлагийн ба шинжлэх ухааны зүтгэлтэнийг харилцан явуулах, 4-р, хоёр орны хооронд кино зураг, ном хэвлэл солилцох зэрэг саналуудыг дэвшүүлжээ.<sup>4</sup> Хэлэлцээрийн хэлбэрийн хувьд аль аль тал нь бодит байдлыг чухалчилдаг байсан байна. 10 дугаар сарын 18-ны өдөр элчин сайд Б.Жаргалсайхан Гадаад явдлын яамандаа илгээсэн захидалд: "Хятадын олон хот, мужуудын хэдэн мянган байгууллагууд манайд маш их хэмжээний зүйлсийг илгээнэ, бид хариу барихад бэрхшээлтэй байдалд хүрч магад" тул хоёр орны соёлын байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтоох гэсэн зүйлийг хассан хэмээн чухалчлав. Тус захидалд тэрбээр мөн Хятадын тал бусад социалист улсуудтай харилцсан туршлагын үндсэн дээр нэг ерөнхий хэлэлцээрийг байгуулах хандлагатай хэмээн дурдав.<sup>5</sup> Үнэндээ Монголын тал бас адил бодолтой байсан тул хоёр тал нэг ерөнхий хэлэлцээрийг байгуулан харин тодорхой зүйлүүдийг жил бүрийн дипломат зөвлөлдөөнөөр шийдэхээр тохиролцов.<sup>6</sup>

<sup>2</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-85, 20-р хуудас

<sup>3</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-66, 60-р хуудас

<sup>4</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-66, 61-р хуудас

<sup>5</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-66, 64-65-р хуудас

<sup>6</sup> Мөн тэнд.

Хоёр тал урьдчилсан зөвшилцөлд хүрсний дараа хэлэлцээр 2 дугаар үе шатанд оржээ. Тус үе шатны хамгийн чухал онцлог бол талууд хоёр хэлэлцээрийг нийлүүлээд эдийн засгийн ба соёлын хамтын ажиллагааны нэг ерөнхий хэлэлцээрийг байгуулахаар шийджээ. Бидний үзсэн эх сурвалжуудын хүрээнд авч үзвэл яагаад ийм шийдвэр гаргасан нь тодорхойгүй байна. Гэвч хэлэлцээр байгуулах тухай яриа хэлэлцээ ид хийгдэж байх тухайн үед эдийн засгийн хувьд тун хүнд нөхцөлд байсан Хятадын тал эдийн засгийн хэт их тусламжийг Монголын тал хүсэхээс сэргийлэх үүднээс соёлын харилцааг нь илүү чухалчлах хандлагатай байсан байж болох юм<sup>7</sup> хэмээн судлаач тэмдэглэснийг дурдах нь зүйтэй юм. Энэ хандлага нь хоёр орны соёлын харилцааг эхлээд хөгжүүлэх хэрэгтэй гэсэн Лю Шаоци-ийн санаатай нийцэж байгаа юм. Тиймээс эдийн засгийн хамтын ажиллагааг хэт чухалчлахаас зайлсхийхийн тулд Хятадын тал хоёр хэлэлцээрийг нийлүүлэх саналыг дэвшүүлсэн байх магадлалтай.

Гэсэн хэдий ч хоёр орны хоорондын анхны чухал хэлэлцээрийн хувьд «Эдийн засгийн ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» нь талуудын харилцааг хөгжүүлэх чухал бэлэг тэмдэг төдийгүй социалист лагерийг бэхжүүлэх үйл явдал хэмээн үзэж байв. 1952 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн МАХН-ын тогтоолд: “Эдийн засаг ба соёлын харилцааг цаашид улам хөгжүүлэн бэхжүүлэх явдал нь манай хоёр улсын ард түмний амьдралын ашиг сонирхолд бүрэн нийлж байгаа төдийгүй агуу их ЗХУ-аар толгойлуулсан энх тайван ардчилал, социализмын лагерийг бэхжүүлэх хэрэгт тус нэмрийг оруулах” хэмээн онцлон заасан байна.<sup>8</sup>

Тус хэлэлцээрт гарын үсэг зурахын тулд 9 дүгээр сарын 28-ны өдрөөс БНМАУ-ын удирдагч Ю.Цэдэнбал өөрийн биеэр БНХАУ-д айлчлав. БНХАУ-тай харилцах харилцааг үнэлэхдээ тэрбээр “агуу их ЗХУ ба агуу их БНХАУ-тай ах дүүгийн эвдэршгүй найрамдлыг бүх талаар бэхжүүлэх явдлыг өөрийн эрх чөлөө, тусгаар тогтнолын бат бэх баталгаа мөн гэж Монголын ард түмэн үзэж байна”<sup>9</sup> хэмээжээ. Эндээс харахад Монголын тал БНХАУ-тай харилцах харилцаагаа өөрийн үндэсний аюулгүй байдал, олон улсын статусаа дээшлүүлэхтэй холбон үзэж байв. «Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» бол чухамдаа БНХАУ-тай харилцах харилцаагаа хөгжүүлэх эхний чухал алхам байлаа.

10 дугаар сарын 4-ний өдөр Ю.Цэдэнбал, Жоу Энълай нар тус тусын засгийн газрынхаа өмнөөс «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-т гарын үсэг зурав. Тус хэлэлцээр нь 10 жилийн хугацаатай. Түүний 1-р зүйлд “Хэлэлцэгч этгээд нь... соёл, гэгээрлийн талаар хамтын ажиллагааг тогтоож хөгжүүлэн бэхжүүлэхээр

<sup>7</sup> 石郡湘, 中蒙关系分析 (1949-1965), 硕士学位论文, 外交学院国际关系系, 2010年.

<sup>8</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-136, 68-р хуудас

<sup>9</sup> ГХТА, Ф-5, Д-2, ХН-136, 81-83-р хуудас

хэлэлцэн тохиров” хэмээн заав. Харин энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд 2-р зүйлд “хоёр орны ... соёл-гэгээрлийн зохих албан газруудын хооронд жич тодорхой хэлэлцээрүүд тогтоогдож байх болно” гэж заасан аж.<sup>10</sup> Эдгээр зүйлүүдээс харахад хоёр орны соёлын харилцааг хөгжүүлэхэд тухайн хэлэлцээр суурь үүрэг гүйцэтгэх шинжтэй харагдаж байна.

### **БНМАУ ба БНХАУ-ын соёлын харилцааны “Алтан үе” (1954-1960 он)**

1953 оноос хойш Монгол, Хятадын соёлын харилцаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлс улам таатай болов. Тухайлбал, тус онд ЗХУ-д И.Сталин нас барж, Н.Хрущевийн “дулаарлын үе” эхлэв. Ийм уур амьсгалд социалист орнуудын соёлын солилцоо ч идэвхэжсэн юм. Үүнээс гадна, Солонгосын дайн дууссаны дараа Хятадын дотоод болон олон улсын нөхцөл байдал улам сайжирч, Хятад, Зөвлөлтийн холбооны харилцаа улам бэхжих болсон байна. Өөрөөр хэлбэл Хятад, Зөвлөлтийн холбоонд төвлөрсөн социалист лагерь нь 1950-иад оны дунд үеэс улам өргөжин тэлэх болов. Ийм таатай орчин дор Монгол, Хятадын соёлын харилцаа “Алтан үе” шатандаа орж эхлэв.

1954 онд жилийн соёлын хамтын ажиллагааны механизм бий болсон явдал нь Монгол, Хятадын соёлын харилцаа “Алтан үе”-дээ орох онцлог шинж тэмдэг болов. 1953 оны сүүлчээр Хятадын талын санаачилгаар талууд 1952 оны «Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийн дагуу дараа жилийнхээ соёлын хамтын ажиллагааг төлөвлөн явуулахаар хэлэлцэн тогтоожээ. Энэ бол хоёр улсын хооронд соёлын харилцааг цаг үеийн байдал хийгээд хэрэгцээ шаардлагад нийцүүлэн уян хатан хөгжүүлэх гэсэн хүчин чармайлтын үр дүн болсон ба 1954 онд хоёр улсын анхны нэг жилийн соёлын хамтын ажиллагааны төлөвлөгөө тухайн жилдээ амжилттай хэрэгжсэн билээ. 1954 оны төлөвлөгөөнд хоёр улс соёлын төлөөлөгчдийг солилцох, урлагийн бригад солилцох, оюутан ба багш солилцох, кино солилцох, үзэсгэлэн, соёлын материал солилцох, уран зохиолын бүтээл харилцан орчуулах, соёлын байгууллагуудын хоорондын харилцааг тогтоох зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тусгажээ. Түүнээс хойш жил жилийн соёлын хамтын ажиллагааны төлөвлөгөөнүүд нь үндсэндээ энэ хүрээнд боловсруулагдан батлагдаж байсан юм. 1954 онд тухайн жилийн соёлын хамтын ажиллагааны механизмыг байгуулж чадсан явдал нь хоёр орны соёлын харилцааг тогтвортойгоор дүрэм, журамтайгаар хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж өгсөн байна.

1950-иад оны сүүлийн хагаст жилийн соёлын хамтын ажиллагааны механизмыг жилээс жилд урьд өмнөхөөсөө сайжруулж боловсронгуй болгосноор Монгол, Хятадын соёлын харилцаа улам хөгжсөн байна. Энэ

<sup>10</sup> Ч.Дашдаваа, Ч. Болд, Жоу Эньлай ба Монгол Орон, УБ., 2014. Хуудас-34

нь үндсэндээ дараах талаар илэрч байв. Юуны түрүүнд, соёлын хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлжээ. Жишээлбэл: хоёр талын соёлын харилцаа нь аажмаар шинжлэх ухааны солилцоо, спортын солилцоо, техникийн солилцоо, эрүүл мэндийн салбарын солилцоо зэргээр өргөжин тэлж байв. Хоёрт: хоёр орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг соёлын байгууллагуудын хооронд албан ёсны хамтын ажиллагаа дараа дараалан тогтох болов. Үүнд, «Үнэн сонин» ба «Ардын өдрийн сонин», Монголын Шинжлэх ухааны хүрээлэн ба Хятадын Шинжлэх ухааны академи, Монголын Төв номын сан ба Бээжингийн Номын сан, Монгол улсын их сургууль ба Бээжингийн их сургууль зэрэг байгууллагууд шууд албан ёсны харилцаа тогтоожээ. Гуравт: соёлын хамтын ажиллагааны талаарх хэд хэдэн гэрээ, хэлэлцээр байгуулагдав. Үүнд «Радиогийн хамтын ажиллагааны хэлэлцээр» (1955), «Кино мэдээ солилцох хэлэлцээр» (1956), «Кино солилцох гэрээ» (1959), «Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны хэлэлцээр» (1960) гэх мэт.

Улмаар 1958 онд «Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийг байгуулснаар хоёр улсын хоорондох жилийн соёлын хамтын ажиллагааны механизм албан ёсоор бүрэлдэн тогтож, үүнийг дагаад соёлын хамтын ажиллагааны хүрээ хэмжээ, өрнөл үйл явдал дээд цэгтээ хүрч очсон байна. Энэ хугацаанд хоёр тал соёлын хамтын ажиллагаандаа урьд өмнө байгаагүй өвөрмөц гурван төслийг хэрэгжүүлсэн нь хоёр орны соёлын харилцааг харилцан солилцохоос хамтран бүтээх шинэ шатанд гаргасан байна. Хоёр улсын киноны хамтын бүтээл нь хоёр орны найрамдалт харилцааг харуулсан кино бүтээх зорилготой төдийгүй хоёр улсын “Социалист лагерийн ижилсэл”-ийг бэхжүүлэх гадаад бодлогын тусгал байжээ. Бусад хоёр төсөл нь хоёр улс интернационализмын үзэл санаагаар үндсэрхэг үзлийг давах гэсэн оролдлого байв. Түүний нэг нь, Өвөр Монголд кирилл үсэг нэвтрүүлэх ажил байсан ба энэ нь Нармай Монголын үзлийг өдөөх магадлалтай нэлээд эмзэг асуудал байв. Нөгөөх нь, «БНМАУ-ын түүх» гурван ботийг хамтран зохиох ажил байсан ба хоёр тал үндэснийхээ байр сууриас шалтгаалан тодорхой түүхэн асуудал, түүхэн хүмүүсийн талаар үнэндээ ялгаатай дүгнэлт, байр суурьтай байжээ. Гэсэн хэдий ч тухайн үед эдгээр үндсэрхэг үзэл санал зөрөлдөөнийг пролетарийн интернационализмын онолоор шийдвэрлэх боломжтой гэж хоёр тал үзэж байсан байна.

Гэвч, 1950-иад оны сүүлээр Монгол, Хятадын соёлын харилцааны цаашдын хөгжилд тухайн цагийн олон улсын харилцааны нөхцөл байдал ялангуяа Хятад, Зөвлөлтийн найрсаг харилцааны эрч саарах болсон нь сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тухайн үеийн ХКН ба ЗХУКН олон улсын хэд хэдэн асуудал хийгээд коммунизм байгуулах асуудлаар санал зөрөлдөөнтэй болсноор харилцаа нь аажмаар хүйтэрч эхлэв. Тухайлбал, Хятадын удирдагчид гадаад бодлогын асуудалд Өрнөдийн орнуудтай энх тайвнаар

зэрэгцэн орших хэмээсэн Н.Хрущёвын "Дулаарлын үе"-ийн Зөвлөлтийн бодлогыг эрс шүүмжилж, капитализмтай үл эвлэрэх, тэмцэх урьдын бодлогоо эрс тууштай хадгалах шаардлагатайг илэрхийлж, өөрсдөө ч энэ суурин дээр бат зогсож байлаа. Түүнчлэн коммунизм байгуулах асуудал дээр Зөвлөлтөөс түрүүлж коммунизмыг байгуулах боломжтой хэмээж үүнийг хэрэгжүүлэхийн тулд "Их үсрэлт", "Ардын коммун" зэрэг өргөн цараатай хувьсгалт бодлогыг боловсруулж, улс даяар их хүчээр хэрэгжүүлэх хандлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, БНХАУ нь ЗХУ-аас өөр хувилбар бүхий социалист хөгжлийн замналыг дэвшүүлэн хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэ байдал нь БНМАУ-ыг хүссэн ч эс хүссэн ч Хятад, Зөвлөлтийн өрсөлдөөний талбар болгож, Зөвлөлт, Хятадтай харилцах тус улсын харилцааг эмзэг тодорхойгүй байдалд эрхгүй түлхэн оруулсан байна. Социалист лагерийн ийм нөхцөл байдлын өөрчлөлт ба Хятадын дотоодын зарим өөрчлөлт нь дээр дурдсан 3 төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг хумьсан юм. Гэсэн хэдий ч тэр үеийн Хятад, Зөвлөлтийн хоорондох зөрчилдөөн нь ил тод бус зөвхөн нам хоорондын маргаанаар хязгаарлагдаж байсан тул социалист лагерийн эв нэгдэл болон Монгол, Хятадын соёлын харилцаанд тодорхой нөлөө үзүүлэх хэмжээнд хүртэл хурцдаагүй байсан хэмээн үзэж байна.

### **Дүгнэлт**

Монгол-Хятадын хооронд 1952 онд байгуулагдсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» нь анх удаа хоёр орны соёлын харилцаагаа хөгжүүлэх ерөнхий зорилгоо илэрхийлэн мөн 1950-иад оны хоёр орны соёлын салбарын харилцааны өргөжилтийн суурь болсон байна. Энэ хэлэлцээрийн дагуу хоёр тал засгийн газруудынхаа тэргүүлсэн жилийн соёлын хамтын ажиллагааны механизмаар соёлын солилцоог явуулсаар иржээ. Энэ явцад хоёр улсын соёл боловсролын олон байгууллага хооронд хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрүүд дараалан байгуулагдсан ба тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хоёр талын хамтын хүчин чармайлт нь Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааг соёлын салбарт богино хугацаанд эрчимтэй хөгжүүлсэн түүхэн чухал ач холбогдолтой байжээ.

1950-иад онд БНМАУ, БНХАУ хоёр нь социалист лагерийн хүрээнд "Пролетарийн интернационализмын уриа"-н дор соёлын харилцаагаа өргөн дэлгэр хөгжүүлсэн боловч, үүнд нөлөөлөх гадаад хүчин зүйл байжээ. Энэ нь Хятад, Зөвлөлтийн харилцааны асуудал бөгөөд тэдний социалист байгуулалтын талаарх санал зөрөлдөөн хийгээд олон улсын ажилчны хөдөлгөөнд гарсан хагарал нь Монгол болон Хятадын соёлын харилцааны хөгжлийн ерөнхий чиг хандлагад нөлөөлсөн байна.

Эртнээс уламжилсан хоёр ард түмний сэтгэлгээ дэх түүхэн сөрөг хүчин зүйлсийг арилгахын тулд БНМАУ, БНХАУ хоёул пролетарийн интернационализмын туг доор соёлын солилцоог хэрэгжүүлсэн нь нийтлэг бөгөөд шинэлэг үзэлтийг бий болгоход чиглэж байжээ. Түүнчлэн соёлын солилцоо нь эргээд хоёр орны харилцаанд пролетарийн интернационализм төлөвшихөд түлхэц өгсөн юм. Хэдийгээр засгийн газрууд удирдсан шинж чанартай байсан ч энэ явцад хоёр ард түмний солилцоо ба харилцан ойлголцол 1950-иад онд урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн бөгөөд зөвхөн Засгийн газрын харилцааны түвшинд төдийгүй “ардын дипломат” харилцаа хөгжихөд хүргэсэн нь түүхэн улбаатай сэтгэлгээний эсрэгцлийг ямар нэгэн хэмжээгээр бууруулж өгсөн гэлтэй.

Эцэст нь хэлэхэд социалист лагерь болон социалист орнуудын харилцааг холбосон зүйл үнэндээ бол нам хоорондын харилцаа байсан юм. Пролетарийн интернационализм өөрөө үнэндээ коммунист намуудын харилцааг зохицуулах үзэл баримтлал байв. Иймд нам хоорондын харилцаа хэлбэлзвэл улсын харилцаа тэр дундаа соёлын харилцаанд мөн тэр чинээгээр нөлөөлөх болсон нь 1950-иад оны сүүлээр БНМАУ ба БНХАУ-ын соёлын харилцааны хэлбэлзэлээс тод харагдаж байна.